



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
АЛБАН ДААЛГАВАР

2009 . снл 03 сарын 13

Дугаар 01

Арванхоёр

Төрийн албан хаагчдын манлайлал,  
ажлын хариуцлагыг өндөржүүлэх тухай

Улс орны, улс төрийн шинэ нөхцөл байдал нь ард иргэд Та биднээс шинэ хандлага, шинэ арга барилаар ажилдаа хандаж, ажил үүргээ мэргэшлийн өндөр түвшинд гүйцэтгэхийг улам ихээр шаардаж, хүсэн хүлээж байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилго, зорилтуудын үзэл баримтлал, "Төрийн албанд шударга шуурхай, ил тод байдлыг хэвшүүлэх нь" аймгийн зөвлөлгөөнөөс гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор ДААЛГАХ нь:

Нэг. Сумдын Засаг дарга, төсвийн ерөнхий менежер нарт:

1.1.Байгууллага, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг хуулийн хүрээнд хүртээмжтэй, шуурхай, хүнд суртал, чирэгдэлгүй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, идэвх санаачлагатай менежер бүхий чадварлаг эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг орон нутагт бий болгон төлөвшүүлэх.

1.2.Төрийн бүх шатны байгууллагын удирдлага, тэдгээрийн албан хаагчдын ажлын хариуцлага, дэг журмыг чангатгаж, төрийн албаны ёс зүйн дүрэм, стандартыг чанд мөрдүүлж, зөрчил дутагдал гаргасан этгээдэд хариуцлага тооцож, ажлаас нь халах хүртэл арга хэмжээг авч байх.

1.3.Төрийн байгууллага, албан хаагчдын ажлын шударга, шуурхай байдал ямар түвшинд байгааг үнэлж, дүгнэн тодруулах зорилгоор жил бүр иргэд, байгууллагаас сэтгэл ханамжийн судалгаа, тандалт хийх ажлыг төрийн болон төрийн бус, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, түүний мөрөөр оновчтой, тодорхой ажлуудыг хийж хэвших.

1.4.Төрийн албан хаагчдын сул орон тоонд тухайн ажлын байрны ерөнхий ба тусгай шаардлагыг хангасан, сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэнийг томилж байх.

Хоёр. Төрийн нийт албан хаагчдад:

2.1.Төрийн албан хаагч бүр хариуцсан ажилдаа өөриймсөг, манлайлагч, шинэлэг зүйлийг санаачлагч, суралцагч, бүтээлч, хээл хахууль авах, өгөх, зуучлах явдлыг эс үйлдэгч байх зарчмыг хувь хүний эрхэмлэн дээдлэх үнэт зүйл болгон нэн тэргүүнд баримтлан ажиллах.

2.2.Байгууллагын дотоод журам, сахилгын болон ёс зүйн дүрмийн шаардлагыг сахин биелүүлээгүй, ажлын байранд болон албан үүргээ гүйцэтгэж явах үедээ архидан согтуурсан тохиолдлыг ажлаас чөлөөлөгдөх, халагдах үндэслэл болгож, шийдвэртэй арга хэмжээг авч байх.

2.3.Төрийн албан хаагч бүр цагийг зүй зохистой ашиглаж, цаг ашиглалтын талаар байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс ямар нэг гомдол, зөрчил гаргахгүй ажиллах.

2.4.Менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээнд хүлээсэн үүргээ нэр төртэй ажил хэрэг болгон үйл ажиллагаагаа шинэ хандлага, шинэ арга барилаар өөрөөсөө эхлэн өөрчилж, чанаргүй буюу хүлээгдэж буй ажлынхаа төлөө хариуцлага хүлээдэг байх.

Гурав. Энэхүү албан даалгаврыг ил тод нийтэд сурталчлах, төрийн албан хаагчдын үр дүнгийн гэрээнд тусгах, биелэлтийг тооцохдоо төрийн үйлчилгээний ажлын шударга, шуурхай, цэвэр тунгалаг байдлыг хэрхэн хангаж ажиллаж байгааг олон нийт, хамт олны санал дүгнэлт, үнэлгээнд тулгуурлан нэг гол үзүүлэлт болгон дүгнэж байхыг сумдын Засаг дарга, төсвийн ерөнхий менежер нарт үүрэг болгож байна.

Дөрөв. Албан даалгаврын хэрэгжилтийн явцыг жил бүрийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж, хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн дарга /Н.Энхцэцэг/-г үүрэг болгож байна.



ЗАСАГ ДАРГА

Д.ТОГТОХСҮРЭН